



**ХЭНГИЙ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХОЁРДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 07

Чингис хот

**Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хоёрдугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Ц.Идэрбат/-д үүрэг болгосугай.
3. Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлогын хороодод даалгасугай.

ДАРГА

Г.ХЭРЛЭНЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Хоёрдугаар Хуралдааны 07 дугаар тогтоолын хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН 2021 ОНЫ
ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2021 онд хүрэх түвшин, үр дүн	2021 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Хариуцах газар, хэлтэс
1	2	3	4	5	6	7
1. Төрийн үйлчилгээний чанар төрийн албан хаагчийн мэдлэг, чадварыг сайжруулан, сахилга, хариуцлагыг чангатгах, авилгатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр: /1 зорилт /						
Хөрөнгө оруулалтын талаар:						
1.1	ХАХТЖҮЧ-5.2.1, АЗДҮАХ-ийн 4.2.3	Төрийн байгууллагуудын ажиллах орчин нөхцлийг сайжруулж, албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэх системийг нэвтрүүлж эхэлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	575.66	ОНТ ТЗУХ
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлж нийт гэмт хэрэг, иргэдийн өмчийн эсрэг хулгайн гэмт хэргийг бууруулан, гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээр: /2 зорилт/						
Хөрөнгө оруулалтын талаар:						
2.1	ХАХТЖҮЧ-7.1.2, АЗДҮАХ-ийн 4.3.5	Хилийн заставуудыг цахилгаан үүсгэврээр хангаж, орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаа болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын сургалтын төвийн барилгад дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	50.00	ОНТ ХЭЗХ, ХЦА
2.2	ХАХТЖҮЧ-7.3.1, АЗДҮАХ-ийн 4.3.5	Цагдаагийн газрыг компьютер техник хэрэгслээр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	20.00	ОНТ ХЭЗХ, ЦГ
3. Нийгмийн хамгааллыг оновчтой хүртээж, хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр: /2 зорилт/						
3.1	ХАХТЖҮЧ-2.3.2, АЗДҮАХ-ийн 6.2.5	Баянхутаг, Дархан сумдын ахмадын байранд хөрөнгө оруулалт хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	60.00	ОНТ НБХ, Сумдын ЗДТГ
3.2	ХАХТЖҮЧ-2.3.2, АЗДҮАХ-ийн 6.2.5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ахмадын сувиллыг өргөтгөх	Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар	100	300.00	УТХО ХОХБТХ, НБХ, ГХБХБГ

4. Хүн бүрт сурах таатай орчинг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй аймаг болох чиглэлээр: /4 зорилт/

Хөрөнгө оруулалтын талаар:

4.1	ХАХТЖҮЧ-2.1.3, АЗДҮАХ-ийн 2.3.8	Шаардлагатай цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	Засвар хийгдэх цэцэрлэгийн барилгын тоо	4	285.00	ОНХС	НБХ, СӨБ, ГХБХБГ
4.2	ХАХТЖҮЧ-2.1.3, АЗДҮАХ-ийн 2.3.8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдан батлагдсан барилгын ажлуудыг хэрэгжүүлэхэд орон нутгийн зүгээс хамтран ажиллана.	Ашиглалтад орох цэцэрлэгийн өргөтгөлийн тоо, их засвар хийх цэцэрлэгийн тоо	3, 1,	2,810.00	УТХО	НБХ, СӨБ, ГХБХБГ
4.3	ХАХТЖҮЧ-2.1.3, АЗДҮАХ-ийн 2.3.8	Дархан сум, Өлзийт тосгоны ЕБС-д хөрөнгө оруулалт хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	105.00	ОНХС	НБХ, ЕБС, ГХБХБГ
4.4	ХАХТЖҮЧ-2.1.3, АЗДҮАХ-ийн 2.3.9	Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдан батлагдсан барилгын ажлуудыг хэрэгжүүлэхэд орон нутгийн зүгээс хамтран ажиллана.	Ашиглалтад орох сургуулийн барилгын тоо, дотуур байрын тоо, их засвар хийгдэх сургуулийн тоо	2, 2, 4,	5,375.00	УТХО	НБХ, ЕБС, ГХБХБГ

5. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай соёлын бүтээлийг дэмжин соёл, урлагийн байгууллагын өрсөлдөх чадвар, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр: /2 зорилт/

Хөрөнгө оруулалтын талаар:

5.1	ХАХТЖҮЧ-1.2.1, АЗДҮАХ-ийн 2.5.1	Хан Хэнтий чуулга, Орон нутаг судлах музейн барилга, Мөрөн сумын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, 3 суманд соёлын төвийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	6,434.10	УТХО	ХОХБТХ, НБХ, ГХБХБГ, БСУГ
5.2	ХАХТЖҮЧ-1.2.1, АЗДҮАХ-ийн 2.5.1	Шаардлагатай соёлын төвийн барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	Засвар хийгдэх объектын тоо	1	600.00	УТХО	ХОХБТХ, НБХ, ГХБХБГ, БСУГ

6. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эмчлэх арга хэмжээг эрчимжүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цахим системийг нэвтрүүлэн чанар хүртээмжийг сайжруулж, хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр /4 зорилт/

Хөрөнгө оруулалтын талаар:

6.1	ХАХТЖҮЧ-2.2.3, АЗДҮАХ-ийн 2.1.9	Хэрлэн сумын өрхийн ЭМТ-ийг авто машин тоног төхөөрөмжөөр хангаж, Баян-Адарга сумын ЭМТ-ийн барилгын гадна шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	62.00	ОНХС	НБХ, ЭМГ
6.2	ХАХТЖҮЧ-2.2.3, АЗДҮАХ-ийн 2.1.10	Нэгдсэн эмнэлгийг компьютер техник хэрэгслээр хангаж, үйлчилгээний ажиллагсдын халдвар хамгааллыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	29.84	ОНТ	НБХ, ЭМГ, НЭ
6.3	ХАХТЖҮЧ-2.2.3, АЗДҮАХ-ийн 2.1.10	Шаардлагатай сумдын эрүүл мэндийн байгууллагын барилгуудыг шинээр барих засварлах ажлыг хэрэгжүүлнэ.	Ашиглалтад орох барилгын тоо, Барилгын ажил эхлэх объектын тоо, засварлах объектын тоо	4, 2, 1,	3,628.00	УТХО	ХОХБТХ, НБХ, ЭМГ, ГХБХБГ
6.4	ХАХТЖҮЧ-2.2.3, АЗДҮАХ-ийн 2.1.11	Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгын их засварыг хийж гүйцэтгэх	Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар	100	690.00	УТХО	ХОХБТХ, НБХ, ЭМГ, ГХБХБГ
7. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж, орон сууцны хангамжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэмэгдүүлэн, холбоо, цахилгаан, дулаан хангамжийн чанар хүртээмжийг сайжруулж, агаарын болон авто зам, гүүр ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр: /11 зорилт/							
Хөрөнгө оруулалтын талаар:							
7.1	ХАХТЖҮЧ-4.2.3, АЗДҮАХ-ийн 3.5	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлнэ.	Ажлын явц, хувиар	100	199.62	ОНХС	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
7.2	ХАХТЖҮЧ-4.2.5, АЗДҮАХ-ийн 3.5.10	Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлнэ.	Ажлын явц, хувиар	100	335.90	ОНХС	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
7.3	ХАХТЖҮЧ-8.1.5, АЗДҮАХ-ийн 3.5.12	Хэрлэн суманд нийтийн тээврийн автобусны буудлуудыг байгуулж, үйлчилгээ үзүүлэх автобусны тоог нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	210.00	ОНХС	ХОХБТХ, Хэрлэн сумын ЗДТГ

7.4	ХАХТЖҮЧ-4.2.3, АЗДҮАХ-ийн 3.5	Орон нутгийн өмчит байгууллагуудыг техник, тоног төхөөрөмжөөр хангах	Техник тоног төхөөрөмжөөр хангагдах байгууллагуудын тоо	2	244.00	ОНХС	ХОХБТХ
7.5	ХАХТЖҮЧ-4.2.3, АЗДҮАХ-ийн 6.1.7	Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станцын ажлыг эхлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар	20 хүртэл	1,000.00	УТХО	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
7.6	ХАХТЖҮЧ-4.2.3, АЗДҮАХ-ийн 3.5.5	Цэнхэрмандал сумын үерийн далангийн байгууламжийг ашиглалтад оруулж, Хэрлэн сумын үерийн хамгаалалтын байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	3,481.00	УТХО	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
7.7	ХАХТЖҮЧ-4.2.3, АЗДҮАХ-ийн 6.2	Галшар суманд "Шинэ сум" төсөл-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Баянмөнх суманд гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэн, Өмнөдэлгэр суманд гадна цэвэр усны шугам сүлжээг ашиглалтад оруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	2,600.00	УТХО	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
7.8	ХАХТЖҮЧ-4.2.3, АЗДҮАХ-ийн 6.2	Тахилгат тосгоны нэгдсэн халаалтын шугам сүлжээний ажлыг хэрэгжүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар	100	300.00	УТХО	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
7.9	ХАХТЖҮЧ-8.1.1, АЗДҮАХ-ийн 3.5	Хэрлэн сумын зам засвар, замын тэмдэглэгээг хийж, гэрлэн дохиог шинэчлэн, 3, 4-р багт явган хүний замыг шинээр тавих, Цэнхэрмандал сумын төвөөс Огзомын цайны газар хүртэлх замын засварыг хийж гүйцэтгэх	Ажлын гүйцэтгэлийн явц, хувиар	100	275.80	ОНЗС	ХОХБТХ, ГХБХБГ, ЦГ, Сумын ЗДТГ

7.10	ХАХТЖҮЧ-4.2.8, АЗДҮАХ-ийн 3.5.10	Даланжаргалан-Бор-Өндөр, Чингис хот-Бэрх, Чингис хот - Дадал чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Мөрөн сумын төвийн хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах	Тухайн жилийн хэрэгжилт, хувиар	100	33,985.50	УТХО	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
7.11	ХАХТЖҮЧ-4.2.7, АЗДҮАХ-ийн 3.5.13	Дэлүүн болдог нисэх буудлын барилгыг ашиглалтад оруулах	Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар	100	4,000.00	УТХО	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
8. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулж нөхөн сэргээх чиглэлээр: /2 зорилт/							
8.1	ХАХТЖҮЧ-6.2.2, АЗДҮАХ-ийн 5.1.7	Байгаль, ан амьтан, ёс заншил танин мэдэхүйн төсөл хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	50	50.00	ОНТ	ХОХБТХ, БОАЖГ
8.2	ХАХТЖҮЧ-6.4.3, АЗДҮАХ-ийн 5.1.3	Бор-Өндөр суманд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100.00	ОНХС	ХОХБТХ, БОАЖГ, сумын ЗДТГ
9. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I"-ийг хэрэгжүүлж, Түүхэн аялал жуулчлал, үндэсний онцлог шингэсэн арга хэмжээнүүдийг сурталчлах чиглэлээр: /1 зорилт/							
9.1	ХАХТЖҮЧ-4.2.2, АЗДҮАХ-ийн 3.4.3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан "Их хуралдай", "Монголын нууц товчоо" цогцолборын барилгын ажлуудыг дуусгахад орон нутгийн зүгээс хамтарч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	3,200.00	УТХО	ХОХБТХ, БОАЖГ, ГХБХБГ
10. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэн малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулах чиглэлээр: /1 зорилт/							
10.1	ХАХТЖҮЧ-8.3.5, АЗДҮАХ-ийн 3.3.4	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох тоног төхөөрөмжөөр хангана.	Хангагдах тоног төхөөрөмжийн тоо	Элиза аппарат-1, Автоклав-1	32.00	ОНХС	ХОХБТХ, МЭГ
11. Иргэдийн амьдрах орчныг сайжруулах чиглэлээр: /3 зорилт/							
Хөрөнгө оруулалтын талаар							
11.1	ХАХТЖҮЧ-2.4.2, АЗДҮАХ-ийн 6.1, 6.2	Шаардлагатай орон сууцны байруудын их засварыг хийж гүйцэтгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	297.40	ОНХС	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ

11.2	ХАХТЖҮЧ-2.4.2, АЗДҮАХ-ийн 6.2	Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	160.00	ОНХС	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
11.3	АЗДҮАХ-ийн 6.2	Хэрлэн, Өмнөдэлгэр сумдад гэрэлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	280.00	ОНХС	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ
12. Бусад чиглэлээр: /1 зорилт/							
Хөрөнгө оруулалтын талаар							
12.1	АЗДҮАХ-ийн 3.5, 6.1, 6.2	Нэн шаардлагатай ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж, он дамжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	1,930.83	ОНХС	ХОХБТХ, ГХБХБГ, Сумын ЗДТГ